



ХОВД АЙМГИЙН
ИРГЭДИЙН ТӨЛӨӨЛӨГЧДИЙН ХУРЛЫН
ТОГТООЛ

2020 оны 11 сарын 24 өдөр

Дугаар 2/01

Ховд

Г

Хэлэлцэх асуудал, дотоод журам, үйлчлэх
Ажлын албадыг батлах тухай

Монгол улсын Засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж, түүний удирдлагын тухай хуулийн 25 дугаар зүйлийн 25.1 дэх заалтыг үндэслэн аймгийн иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын 2 дугаар хуралдаанаас ТОГТООХ нь:

1. Аймгийн Иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын хоёрдугаар хуралдаанд оролцсон төлөөлөгчдийн 100 хувийн саналаар аймгийн Иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын 2 дугаар хуралдааны хэлэлцэх асуудлыг 1 дүгээр хавсралтаар, дотоод журмыг 2 дугаар хавсралтаар, хуралдаанд үйлчлэх Ажлын албадыг 3 дугаар хавсралтаар тус тус баталсугай.



Аймгийн ИТХ-ЫН 2020 оны 2 дугаар
хуралдааны 2/01 дүгээр тогтоолын
1 дүгээр хавсралт

АЙМГИЙН ИТХ-ЫН ХОЁРДУГААР ХУРАЛДААНЫ
ХЭЛЭЛЦЭХ АСУУДАЛ

1. Цахим хуралдааны дэг батлах тухай

Илтгэгч нь: Аймгийн иргэдийн Төлөөлөгчдийн
хурлын нарийн бичгийн дарга Б.Сандагсүрэн

2. Хорооны бүрэлдэхүүн, чиг үүрэг батлах тухай

Илтгэгч нь: Аймгийн иргэдийн Төлөөлөгчдийн
хурлын нарийн бичгийн дарга Б.Сандагсүрэн

3. Аймгийг 2021-2025 онд хөгжүүлэх таван жилийн үндсэн чиглэл батлах тухай

Илтгэгч нь : Аймгийн Засаг дарга Б.Дүгэржав


4. Аймгийн Засаг даргын 2020-2024 оны үйл ажиллагааны хөтөлбөр батлах
тухай

Илтгэгч нь : Аймгийн Засаг дарга Б.Дүгэржав

5. Аймгийн 2020 оны төсөв батлах тухай 10/06 дугаар тогтоолд өөрчлөлт
оруулах тухай

Илтгэгч нь : Аймгийн Засаг дарга Б.Дүгэржав

----оо----



Аймгийн ИТХ-ын 2020 оны 2 дугаар
хуралдааны 2/01 дугээр тогтоолын
2 дугаар хавсралт

ДОТООД ЖУРАМ

- Цахим хуралдааны дэг батлах тухай илтгэл

/5 минут/

- Хорооны бүрэлдэхүүн, чиг үүрэг батлах тухай илтгэл

/5 минут/

- Аймгийг 2021-2025 онд хөгжүүлэх таван жилийн үндсэн чиглэл батлах тухай илтгэл

/10 минут/

- Аймгийн Засаг даргын 2020-2024 оны үйл ажиллагааны хөтөлбөр батлах тухай илтгэл

/10 минут/

- Аймгийн 2020 оны төсөв батлах тухай 10/06 дугаар тогтоолд өөрчлөлт оруулах тухай илтгэл

/ 5 минут /

- Аймгийн ИТХ-ын төлөөлөгчид асуулт асууж, санал хэлнэ.


/Хэлэлцэх асуудал тус бүрт хүн бүр эхний удаа 3 минут,
дараагийн удаа 1 минут/

- Хуралдаанаас гарах шийдвэр батлах

/Цаг тогтоохгүй/

- Хуралдааныг 2 цаг тутамд 10 минутын завсарлагатайгаар товлосон өдөрт багтаан дуусгана.

----oOo----



Аймгийн ИТХ-ын 2020 оны 2-дугаар
хуралдааны 9/01 дүгээр тогтоолын
3 дугаар хавсралт

АЙМГИЙН ИТХ-ЫН ХОЁРДУГААР ХУРАЛДААНД
ҮЙЛЧЛЭХ АЖЛЫН АЛБА

А. Нарийн бичгийн даргаар:

- А.Түмэндэлгэр - Аймгийн ИТХ-ын Тэргүүлэгчдийн Ажлын
албаны НУБЗХ-ийн мэргэжилтэн
Б.Энхбаатар - Аймгийн ЗДТГ-ын ТЗУХ-ийн мэргэжилтэн
Б.Гантөмөр - Аймгийн ЗДТГ-ын ХШҮХ-ийн ахлах мэргэжилтэн

Б. Редакцийн комиссоор:

- Б.Баяртуяа – Аймгийн ИТХ-ын Тэргүүлэгчдийн Ажлын
албаны ОНИХХ-ийн дарга
С.Дорж - Аймгийн ЗДТГ-ын НБХ-ийн мэргэжилтэн

В. Тэмдэглэл хөтлөгчөөр:

- Р.Цэцэгжаргал –Аймгийн ИТХ-ын Тэргүүлэгчдийн Ажлын
албаны НУБЗХ-ийн мэргэжилтэн
С.Батцэцэг -Аймгийн ИТХ-ын Тэргүүлэгчдийн Ажлын
албаны НУБЗХ-ийн мэргэжилтэн

Г. Хэлэлцэх асуудалтай холбогдуулан гарах тогтоолын төсөл боловсруулах
ажлын хэсэг:

- Ахлагч: Б.Сандагсүрэн- Аймгийн ИТХ-ын нарийн бичгийн дарга
Гишүүд: Т.Дэлгэрсайхан - Аймгийн ИТХ-ын төлөөлөгч
Л.Энхбаяр - Аймгийн ИТХ-ын төлөөлөгч
Б.Амаржаргал – Аймгийн ИТХ-ын төлөөлөгч, тэргүүлэгч
Б.Ганболд- Аймгийн Засаг даргын Тамгын газрын Төрийн
захиргаа, удирдлагын хэлтсийн дарга
Б.Баярсүх-Аймгийн Засаг даргын Тамгын газрын Хөрөнгө
оруулалт, хөгжлийн бодлого, төлөвлөлтийн хэлтсийн дарга
Ч.Багдал –Аймгийн Засаг даргын Тамгын газрын Санхүү,
төрийн сангийн хэлтсийн дарга
Н.Ганзориг- Аймгийн Засаг даргын Тамгын газрын Хууль,
эрх зүйн хэлтсийн дарга

---оо---



ХОВД АЙМГИЙН
ИРГЭДИЙН ТӨЛӨӨЛӨГЧДИЙН ХУРЛЫН
ТОГТООЛ

2020 оны 11 сарын 24 өдөр

Дугаар 2/02

Ховд

Цахим хуралдааны дэг
батлах тухай

Монгол улсын Засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж, түүний удирдлагын тухай хуулийн 23 дугаар зүйлийн 23.14 дэх хэсгийг үндэслэн аймгийн ИТХ-ын 2 дугаар хуралдаанаас ТОГТООХ нь:

- Ховд аймгийн иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын хуралдаан болон Тэргүүлэгчдийн цахим хуралдааны дэгийг хавсралтаар баталсугай.
- Цахим хуралдааны дэгийг мөрдөж ажиллахыг аймгийн иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын Төлөөлөгчид, Хурлын Ажлын алба, Засаг дарга, хуралдаанд оролцогчдод үүрэг болгосугай.





АЙМГИЙН ИТХ-ЫН ХУРАЛДААН БОЛОН ТЭРГҮҮЛЭГЧДИЙН ЦАХИМ ХУРАЛДААНЫ ДЭГ

Нэг. Дэгийн зорилт

1.1. Монгол улсын Засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж, түүний удирдлагын тухай хуулийн 3-р бүлгийн 23.14 дэх хэсэг, Гамшгаас хамгаалах тухай хууль, Ховд аймгийн ИТХ-ын Хуралдааны дэгт тусгагдсаны дагуу байгалийн гамшиг, нийтийг хамарсан эмх замбараагүй байдал, гол түймэр, халдварт өвчин дэгдэх зэрэг нийтийг хамарсан онцгой нөхцөл байдал үүссэн тохиолдолд аймгийн ИТХ-ын Хуралдаан, Тэргүүлэгчдийн хуралдаан болон Хурлын хороо, дэд хороо, түр хороодын хуралдааныг зохион байгуулах, хуралдаанаар тодорхой асуудал хэлэлцэх, санал хураах, шийдвэр гаргах, биелэлтийг хянаж тайлагнахтай холбоотой харилцааг зохицуулахад оршино.

Хоёр. Нийтлэг үндэслэл

2.1. Энэхүү дэгээр зохицуулагдаагүй бусад харилцааг Ховд аймгийн ИТХ-ын 2020 оны Анхдугаар хуралдааны 02 дугаар тогтоолоор баталсан “Хуралдааны дэг”-ээр зохицуулна.

2.2. Энэхүү журмын 1.1-д заасан нөхцлийн үед хуралдааны байршлыг өөрчилж болно.

2.3. Хуралдаан болон Тэргүүлэгчдийн хурал, Хороодын хурал, дэд, түр хорооны хуралдааныг /цаашид “хуралдаан” гэх/ цахим хуралдааны программ ашиглан зохион байгуулах бөгөөд цахим хуралдааны программ нь төлөөлөгчид болон холбогдох албан тушаалтнууд байршилаас үл хамааран дүрсээ харан нэгэн зэрэг сонсох болон ярих боломжтой байна.

2.4. Хуралдааны зарыг албан ёсны цахим шуудан, фэйсбуук хаяг, бусад холбооны хэрэгсэл ашиглан Аймгийн ИТХ-ын Төлөөлөгчдөд мэдэгдэнэ.

Гурав. Цахим хуралдааны үндсэн зарчим

3.1. Төлөөлөгчид товлосон цагт цахим хуралдааны танхимд болон программын ирцэд бүртгүүлэн оролцох үүрэгтэй.

3.2. Хэлэлцэх асуудлын материалыг албан ёсны цахим шуудангаар илгээж, аймгийн ИТХ-ын цахим хуудсанд байршуулна.

3.2. Хэлэлцэх асуудлын материалыг албан ёсны цахим шуудангаар илгээж, аймгийн ИТХ-ын цахим хуудсанд байршуулна.

3.3. Хуралдаанд Төлөөлөгч нь Нутгийн удирдлагын ордны Хуралдааны танхimuуд, өөрийн албан өрөөнөөсөө оролцох бөгөөд хүндэтгэн үзэх шалтгааны улмаас хуралдаан даргалагчид урьдчилан мэдэгдсэн бол тухайн байгаа газраасаа цахим хуралдааныг хэвийн явуулах боломж, нөхцөлийг хангаж оролцно.

3.4. Хуралдаанд тухайн хэлэлцэж байгаа асуудлыг боловсруулахад оролцсон ажлын хэсэг, аймгийн ИТХ-ын Ажлын алба, аймгийн Засаг даргын Тамгын газрын холбогдох албан тушаалтан оролцож болно.

3.5. Тухайн өдрийн хуралдаан эхлэхэд цахим хуралдааны танхимд ирсэн болон программ ашиглаж, оролцсон Төлөөлөгчдийг хуралдаанд хүрэлцэн ирснээр тооцож, хуралдааны ирцэд бүртгэнэ.

3.6. Хуралдааны ирцэд бүртгүүлсэн төлөөлөгчид тухайн хуралдаанаас албан ёсоор чөлөө аваагүй, бүртгэлээс гарахаа өөрөө мэдэгдэж, цахим хуралдаанаас гараагүй тохиолдолд түүнийг хуралдааны ирцэд тооцон тухайн асуудлаар санал хураахад эсрэг санал өгсөнд тооцно.

3.7.Хуралдааны дэг зөрчсөн болон цахим хуралдааны хэлэлцэж байгаа асуудалтай холбогдолгүй зүйл ярих, цахим хуралдааныг хэвийн явуулахад саад учруулсан үйлдэл гаргавал тухайн Төлөөлөгчид хуралдаан даргалагч сануулах, ба сануулга авсан Төлөөлөгч дахин зөрчил гаргавал түүнийг тухайн хэлэлцэж байгаа асуудлаар асуулт асуух, үг хэлэх эрхийг нь хязгаарлаж, энэ тухайгаа мэдэгдэнэ.

3.8. Нам, эвслийн бүлэг хуралдаанаар хэлэлцэж буй тухайн асуудлаар завсарлага авахаар бол бүлгийн даргаараа дамжуулан санал гаргана. Хурлын дарга тухайн саналыг хүлээж авахаар бол хугацааг тогтоож завсарлага өгч болно. Завсарлагын хугацаа 30 минут хүртэл байна. Завсарлагын хугацааг дахин 1 удаа 10 минутаар сунгаж болно.

Дөрөв. Цахим хуралдааны зохион байгуулалт

4.1. Төлөөлөгч хэлэлцэх асуудалтай холбоотой лавлах тодруулах асуудлаа урьдчилан холбогдох албан тушаалтнаас тодруулан мэдээлэл авч танилцсан байх ба цахим хуралдааны үед зөвхөн тухайн хэлэлцэж буй асуудалтай холбоотой асуулт асууж, санал хэлэх эрхээр хангагдана.

4.2. Төлөөлөгч хуралдаанд үг хэлж, байр сууриа илэрхийлэх, тайлбар хийх, асуулт асуухдаа Хуралдаан даргалагчид мэдэгдэн дараалалд орж хуралдаан даргалагчийн зөвшөөрлөөр микрофон нээгдэхэд үг хэлж, асуулт асууна.

4.3. Онцгой нөхцөлд цахимаар хуралдаж байгаа үед асуулт асуух, санал хэлэх хугацаа 3 минутаас илүүгүй, хариулт, тайлбар хангалтгүй гэж үзвэл тухайн Төлөөлөгчийн саналаар 1 удаа 1 минутаас илүүгүй хугацаагаар дахин нэмэлт асуулт асууж, санал хэлж болно.

4.4. Цахим хуралдаанд хэвлэл мэдээллийн байгууллагууд болон хэлэлцэж байгаа асуудалтай холбогдуулан холбогдох албан байгууллага, албан тушаалтныг урилгаар оролцуулж болно.

4.5. Хуралдаанд оролцож байгаа хэвлэл мэдээллийн байгууллага, албан тушаалтан энэхүү дэг болон хуралдааны дотоод журмыг дагаж мөрдөнө.

4.6. Хуралдаанаар хэлэлцэж байгаа асуудлаар илээр болон цахим программ ашиглан санал хураалт явуулах бөгөөд хуралдаан даргалагч санал хураах томьёоллыг урьдчилан мэдэгдэж, санал хураалтын үр дүнг нэгтгэн танилцуулна. Хэрэв нууц санал хураалт явуулах нөхцөл байдал үүссэн тохиолдолд зөвхөн санал хураах хуудсаар явуулна.

4.7. Цахим хуралдаан 2 цаг тутамд завсарлага авч болох ба хуралдааныг мөн өдөрт багтаан дуусгана.

4.8. Хуралдаанд үйлчлэх Ажлын албад цахим хуралдааны танхимд болон программд нэвтэрч хуралдааны үйл ажиллагаанд оролцож тус тусынхаа үүргийг гүйцэтгэнэ.

4.9. Хуралдааны явцыг дуу, дүрс бичлэг, мэдээллийн бусад техник хэрэгсэл ашиглан аймгийн ИТХ-ын Тэргүүлэгчдийн Ажлын алба бэхжүүлэх ба тэмдэглэл хөтлөн цаасан хэлбэрээр архивын нэгж үүсгэн хадгална.

Тав. Бусад

5.1. Хуралдааны дэгийг батлагдсан өдрөөс эхлэн энэхүү дэгийн 1.1 дэх хэсэгт заасан нөхцөл байдал үүссэн гэж үзсэн тохиолдолд дагаж мөрдөнө.



ХОВД АЙМГИЙН
ИРГЭДИЙН ТӨЛӨӨЛӨГЧДИЙН ХУРЛЫН
ТОГТООЛ

2020 оны 11 сарын 24 өдөр

Дугаар 203

Ховд

Г

Хорооны чиг үүрэг, бүрэлдэхүүн
батлах тухай

Монгол улсын Засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж, түүний удирдлагын тухай хуулийн 18 дугаар зүйлийн 18.1.1-ийн “в”, 19 дүгээр зүйл, аймгийн ИТХ-ын 2020 оны анхдугаар хуралдааны 02 дугаар тогтоолоор баталсан “Хуралдааны дэг”-ийн 9 дүгээр зүйлийн 9.2 дахь хэсгийг тус тус үндэслэн аймгийн ИТХ-ын 2 дугаар хуралдаанаас ТОГТООХ нь:

- Аймгийн ИТХ-ын хороодын чиг үүргийг 1 дүгээр хавсралтаар, бүрэлдэхүүнийг 2 дугаар хавсралтаар тус тус баталсугай.
- Хариуцсан чиглэлээр хурлын тасралтгүй, байнгын үйл ажиллагааг хангаж ажиллахыг хорооны ахлагч, гишүүдэд үүрэг болгосугай.

ХУРЛЫН ДАРГА Г ПУРЭВГАНДИ



Аймгийн ИТХ-ын 2020 оны 2 дугаар
хуралдааны 903 дугаар тогтоолын
1 дүгээр хавсралт

АЙМГИЙН ИРГЭДИЙН ТӨЛӨӨЛӨГЧДИЙН ХУРЛЫН ХОРООДЫН ЧИГҮҮРЭГ

1. Нийгмийн бодлогын хороо

Холбогдох чиглэлээр гарсан хөтөлбөр, төлөвлөгөө, тогтоол, шийдвэр, бусад эрх зүйн актуудын хэрэгжилтийг хангуулах, үр дүнд хяналт үнэлгээ хийх, хуралдаанд санал, дүгнэлт оруулах.

- Эрүүл мэнд
- Боловсрол
- Соёл урлаг
- Шинжлэх ухаан, мэдээлэл технологийн хөгжил
- Ард түмний түүх соёл, оюуны өвийг сэргээх, хамгаалах талаарх бодлого
- Монгол хэл, бичиг, соёл, урлаг, ёс заншлын талаар төрөөс баримтлах бодлого
- Хүн амын бодлого
- Нийгмийн хамгааллын бодлого
- Нийтийн биеийн тамир спортын талаарх бодлого
- Хөдөлмөр эрхлэлт, хөдөлмөрийн харилцаа, хөдөлмөр хамгаалал
- Ажлын байр, өрхийн орлого нэмэгдүүлэх, амьдралын чанарыг сайжруулах
- Хүний хөгжлийг дэмжих, иргэд олон нийтийг соён гэгээрүүлэх

2. Нутгийн удирдлага, хууль эрх зүй, гадаад харилцаа, ёс зүйн хороо

▪ Холбогдох чиглэлээр гарсан хөтөлбөр, төлөвлөгөө, тогтоол, шийдвэр, бусад эрх зүйн актуудын хэрэгжилтийг хангуулах, үр дүнд хяналт үнэлгээ хийх, хуралдаанд санал, дүгнэлт оруулах.

- Аймгийн ИТХ-ын болон тэргүүлэгчдийн хурлын тогтоол шийдвэрүүдийн биелэлт, хэрэгжилт, үр дүнг хянах дүгнэлт өгөх
- Ерөнхийлөгч, УИХ, аймаг, сумын Иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын сонгууль
- Нутгийн өөрөө удирдах байгууллага, ИТХ-ын төлөөлөгчдийн ёс зүй
- Төрийн байгууллагууд болон төрийн албан хаагчдын ёс зүй
- Ард нийтийн санал асуулга, хэлэлцүүлэг
- Төр, сүм хийдийн харилцаа
- Төрийн болон төрийн бус байгууллагын оролцоог нэмэгдүүлэх, чадавхжуулах
- Хэвлэл мэдээллийн хэрэгсэл
- Аймгийн ИТХ-ын төлөөлөгчдийн бүрэн эрх, хуралдааны дэг

- ИТХ-ын гадаад харилцаа
- Төрийн үйлчилгээний чанар хүртээмжид хяналт тавьж ажиллах
- Нутгийн өөрөө удирдах байгууллагын ажилтан, сонгуультан, төрийн албан хаагчдыг давтан сургах, мэргэшүүлэх, чадавхжуулах.
- Сумын ИТХ, багийн ИНХурлыг ажлын арга зүйн удирдлагаар хангах
- Төрийн албан хаагчдын нээлттэй, ил тод, шударга сонгон шалгаруулалт, Төрийн албаны хуулийн хэрэгжилтэнд хяналт тавих.
- Үндэсний аюулгүй байдлыг хангах бодлого, чиг үүргийн байгууллагуудын үйл ажиллагаа
- Аймаг, сумын ИТХ-ын төлөөлөгчдийн болон эрх бүхий албан тушаалтнуудын хөрөнгө орлогын мэдүүлэг
 - Гэмт хэрэгтэй тэмцэх, урьдчилан сэргийлэх, хууль сурталчилах
 - Санал, өргөдөл, гомдлын шийдвэрлэлт, хэрэгжилтэнд тавих хяналт
 - Хүчирхийлэл, согтууруулах ундаа, мансууруулах бодис
- 3. Төсвийн хяналт, эдийн засгийн хороо**
 - Холбогдох чиглэлээр гарсан хөтөлбөр төлөвлөгөө, тогтоол, шийдвэр, бусад эрх зүйн актуудын хэрэгжилтийг хангуулах, үр дүнд хяналт үнэлгээ хийх, хуралдаанд санал, дүгнэлт оруулах.
 - Аймгийн төсвийн орлогыг тогтвортой нэмэгдүүлэх боломж нөхцөлийг судлах, орон нутгийн бололцоог илрүүлэх
 - Төсвийг боловсруулах, батлах, гүйцэтгэлийн зохион байгуулалт, түүний үр дүнд тавих хяналт
 - Аймаг сумын ОНХС-гийн үйл ажиллагаа, үр дүн
 - Төрийн санхүү, зээл, тусlamжийн ашиглалт, зарцуулалт, үр ашиг, гааль, албан татварын бодлого
 - Аймгийн эдийн засаг, нийгмийн хөгжлийн үндсэн чиглэл
 - Үнэт цаас, даатгалын бодлого
 - Гадаадын хөрөнгө оруулалт, зээл тусlamжийн нэгдсэн бодлого.
 - Шударга бус өрсөлдөөнийг хязгаарлах бодлого
 - Төрөөс аж ахуй эрхлэлтийг дэмжих бодлого
 - Стандартчилал хэмжил зүй, чанарын баталгаажуулалт
 - Албан ёсны статистикийн үйл ажиллагааны зохицуулалт
 - Төсвийн орлогын бүрдүүлэлтэнд хяналт тавих
 - Төсвийн зарлага, санхүүжилтэнд хяналт тавих
 - Улсын төсвийн болон орон нутгийн төсвийн ХО-ын худалдан авалтын ажиллагааны зохион байгуулалт, хэрэгжилтийн үр дүнд хяналт тавих

- Төрийн болон орон нутгийн өмчийн удирдлага, зохицуулалт, хувьчлалын бодлого

4. Хүнс, хөдөө аж ахуй, байгаль орчин, аялал, жуулчлалын хороо

- Холбогдох чиглэлээр гарсан хөтөлбөр төлөвлөгөө, тогтоол, шийдвэр, бусад эрх зүйн актуудын хэрэгжилтийг хангуулах, үр дүнд хяналт үнэлгээ хийх, хуралдаанд санал, дүгнэлт оруулах.
- Газар, түүний хэвллий, ой, ус амьтан, ургамал, агаар мандал болон байгалийн бусад баялаг
 - Ногоон хөгжлийн бодлого, Ногоон хөгжлийн хөтөлбөрийн хэрэгжилт, үр дүн
 - Аялал жуулчлалын хөгжлийн бодлого, стратеги, “Гурван сэнхэр төвтэй Таван од” аялал жуулчлалын хөтөлбөрийн хэрэгжилт, үр дүн
 - Газар тариалан, үрийн аж ахуй, хүнсний үйлдвэрийн бодлого
 - Хүнс, хөдөө аж ахуйн бүтээгдэхүүний хяналт, хүнсний аюулгүй байдал
 - Улсын тусгай хамгаалалттай газар, бэлчээр, тариалангийн газар
 - Геологи, уул уурхай, ашигт малтмалтай холбогдолтой эрэл, хайгуул, ашиглалтын ажилд тавих байгаль орчны хяналт
 - Агаарын бохирдол, хог хаягдал, хорт бодис, байгаль орчны асуудал
 - Усны бодлого, нөөц ашиглалт, усны бохирдол
 - Ан агнуур
 - Сав газруудын хамгаалалтын асуудал
 - Орчны ногоон бүс, агаарын бохирдлын асуудал
 - Хөдөө аж ахуйн бодлого, олон улсын байгууллагын зээл, тусламжийн гэрээ
 - Мал аж ахуйн бодлого, малын даатгал болон мал эрүүлжүүлэх, үүлдэр угсааг сайжруулах
 - Бэлчээрийн ашиглалт, хуваарилалт, усан хангамжийн бодлого
 - Эрчимжсэн мал аж ахуй хөгжүүлэх, хөдөөгийн ард иргэдийн нийгмийн асуудал
 - Хүнсний захуудын үйл ажиллагаа, эрүүл ахуй, халдвартгүйжүүлэлт
 - ХАА-н бүтээгдэхүүний үйлдвэрлэл, борлуулалт, малчдын нөхөрлөл, хоршооллыг дэмжих, өргөжүүлэх

5. Хөгжлийн бодлого төлөвлөлтийн хороо

- Холбогдох чиглэлээр гарсан хөтөлбөр төлөвлөгөө, тогтоол, шийдвэр, бусад эрх зүйн актуудын хэрэгжилтийг хангуулах, үр дүнд хяналт үнэлгээ хийх, хуралдаанд санал, дүгнэлт оруулах.
- Монгол улсын тогтвортой хөгжлийн хөтөлбөр, үндэсний хөгжлийн цогц бодлого, төрөөс аж үйлдвэрийн талаар баримтлах бодлого, жижиг, дунд үйлдвэрийн бодлого, Ховд аймгийг 2015-2025 он хүртэл хөгжүүлэх стратеги төлөвлөгөө, Ногоон хөгжлийн

хөтөлбөр, Ховд аймгийг хөгжүүлэх 2021-2025 оны таван жилийн үндсэн чиглэл, Аймгийн Засаг даргын 2020-2024 оны үйл ажиллагааны хөтөлбөр

- Жижиг дунд үйлдвэрийг хөгжүүлэх төсөл сонгон шалгаруулах, үйлдвэрийн үр ашгийг дээшлүүлэхэд дэмжлэг туслалцаа үзүүлэх
- Хүн амын эрүүл мэнд, аюулгүй байдал, байгаль орчинд ээлтэй үйлдвэрлэлийг дэмжих бодлого
- Экспортын чиг баримжаатай, импортыг орлох, өрсөлдөх чадвар бүхий эцсийн бүтээгдэхүүний үйлдвэрлэлийг дэмжих бодлого
- Дэвшилтэт техник, технологи, өндөр технологи, инновацид суурилсан эдийн засгийн үр ашигтай үйлдвэрлэлийг дэмжин хөгжүүлэх бодлого
- Аж үйлдвэрийн салбарыг хөгжүүлэхэд төр, шинжлэх ухаан, хувийн хэвшлийн үр ашигтай хамтын ажиллагаанд тулгуурлах бодлого
- Аж үйлдвэрийн салбарт оролцогч талуудын үйл ажиллагаанд тэгш байдал, шударга өрсөлдөөнийг дэмжих бодлого
- Аж үйлдвэрийн салбарын бүтээмж, өрсөлдөх чадварын байдалд судалгаа хийж, аж үйлдвэрийн бүтцийг нэмэгдүүлэх стратегийг баримтлах.
- Үйлдвэрлэлийн бүтээмжийн өсөлт, техник технологийн шинэчлэл
- Барилга, хот байгуулалтын бодлого
- Дэд бүтцийн хөгжлийн бодлого
- Газар, ашигт малтмал ашиглалтын бодлого
- Харилцаа холбоо, мэдээлэл технологи
- Инженерийн шугам сүлжээ, хот төлөвлөлтийн асуудал
- Цэвэр, бохир усны асуудал
- Хог хаягдал, дахин боловсруулалт
- Жижиг дунд үйлдвэрийг хөгжүүлэх
- Үйлдвэрлэл технологийн парк, ХАА-н агро парк, Инкубатор төвийн үйл ажиллагаа, зохион байгуулалт.
- Аймаг, сумын эрчим хүчний хангамж, түүний хүчин чадлыг нэмэгдүүлэх
- Нар, салхи бусад эх үүсвэрийг ашиглах үйл ажиллагааг өргөжүүлэх асуудлыг судалж чиглэл боловсруулах
- Аймгийн хэмжээнд уул уурхайн салбарын хөгжилд тулгуурласан зам тээвэр, эрчим хүч, барилга, хот байгуулалтын хөрөнгө оруулалтын төлөвлөлт, зарцуулалтанд хяналт тавьж санал дэвшүүлж шийдвэрлүүлэх

Аймгийн ИТХ-ын 2020 оны 2 дугаар
хуралдааны 2/03 дугаар тогтоолын
2 дугаар хавсралт

ХОРООНЫ БҮРЭЛДЭХҮҮН

1. Нийгмийн бодлогын хороо:

Ахлагч: Л.Бадамхорлоо

Гишүүд:

1. Б.Амаржаргал
2. Т.Дэлгэрсайхан
3. П.Гэрэлсүрэн
4. С.Баянмөнх
5. У.Цэрэнтогтох
6. Г.Цэдэнбал
7. Б.Батбилэг
8. Ж.Батсайхан
9. Н.Ганбат
10. Д.Цэрэнбадам
11. Б.Нямсүрэн
12. Б.Батбулган
13. Т.Баяртогтох
14. Б.Анхбаяр
15. Ж.Дамдинбазар

2. Хүнс, Хөдөө аж ахуй, Байгаль орчин, Аялал жуулчлалын хороо:

Ахлагч: Д.Цэвээнравдан

Гишүүд:

1. Б.Дүгэржав
2. Н.Батцагаан
3. П.Гэрэлсүрэн
4. Б.Батболд
5. Д.Ганбат
6. Ц.Цогтбаяр

7. Х. Жаукар
8. О. Ганцоож
9. Б. Батбулган
10. Т. Бергенбай
11. Х. Батболд
12. Г. Цэдэнбал
13. Л. Энхбаяр
14. П. Цогбадрах
15. Б. Бадарч
16. Д. Батхуяг

3. Хөгжлийн бодлого төлөвлөлтийн хороо:

Ахлагч: Т. Жаргалсайхан

Гишүүд:

1. Г. Пүрэвганди
2. Б. Дүгэржав
3. М. Ганзориг
4. Д. Эрдэнэцэцэг
5. Д. Бадамсэд
6. С. Баярсайхан
7. Н. Батцагаан
8. О. Ганцоож
9. Д. Ганбат
10. Ц. Цогтбаяр
11. Т. Баяртготох
12. Л. Энхбаяр
13. Д. Цэрэнбадам
14. П. Эрдэнэ-Очир
15. Б. Бадарч

4. Нутгийн удирдлага, хууль эрх зүй, гадаад харилцаа, ёс зүйн хороо:

Ахлагч: Т. Баярсайхан

Гишүүд:

1. Б. Гантулга
2. М. Ганзориг

3. Б.Амаржаргал
4. С.Гантөмөр
5. П.Эрдэнэочир
6. Б. Нямсүрэн
8. С.Баянмөнх
9. Э.Уртнасан
10. Д.Батхуяг
11. Х. Жаукар
12. Б.Батбилэг
13. Т.Бергенбай
- 14.П.Цогбадрах
15. Л.Бадамхорлоо
- 16.Ж.Батсайхан

5.Төсвийн хяналт, эдийн засгийн хороо:

Ахлагч: С.Гантөмөр

Гишүүд:

1. Г.Пүрэвганди
2. Т.Жаргалсайхан
3. Т.Дэлгэрсайхан
4. Т.Баярсайхан
5. Б.Гантулга
6. Б.Батболд
7. Д.Эрдэнэцэцэг
8. Д.Бадамсэд
9. Э.Уртнасан
10. У.Цэрэнтогтох
11. Н.Ганбат
12. Х.Батболд
13. Д.Цэвээнравдан
14. Б.Анхбаяр
15. Ж.Дамдинбазар
16. С.Баярсайхан